

“ГОВЬ” ХУВЬЦААТ КОМПАНИ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТООЛЛОГЫН КОМИССЫН ТОГТООЛ

2025 оны 04 сарын 25 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

Г

Хурлын ирцийн тухай

Г

Говь ХК-ийн 2025 оны 04-р сарын 25-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын ирцийг хурлын даргад мэдээлэх нь:

1. Говь ХК-ийн 2025 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийг бүртгэх бүртгэлийн өдөр нь 2025 оны 04-р сарын 04-ний өдөр байсныг дурдсугай.
2. Бүртгэлийн өдрөөр Говь ХК-ийн нийт саналын эрхтэй хувьцааны тоо **780,112,500** ширхэг байснаас хурлын материалтай урьдчилан танилцан санал өгөх арга хэлбэрээр **13,341,856** ширхэг хувьцааны **1.71** хувийн саналын эрхтэй **563** хувьцаа эзэмшигч, 04-р сарын 25-ны өдрийн хуралд биечлэн оролцох арга хэлбэрээр **681,455,412** ширхэг хувьцааны **87.35** хувийн саналын эрхтэй **99** хувьцаа эзэмшигч оролцсоноор нийт ирц **89.06** хувь болж, хурлын ирц бүрдсэнийг мэдэгдсүгэй.

ТООЛЛОГЫН КОМИССЫН ДАРГА


КОМИССЫН ГИШҮҮД

КОМИССЫН НАРИЙН БИЧИГ




 Н.САЙНЗУЛ

 Ц.ЦЭЦЭГБАДАМ

 Б.УЯНГА

 Б.УРАНГОО

 Г.УУГАНЗАЯА

 Д.САРАНГУА



“ГОВЬ” ХУВЬЦААТ КОМПАНИ
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН
ТООЛЛОГЫН КОМИССЫН ТОГТООЛ

2025 оны 04 сарын 25 өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

Г Санал хураалтын нэгтгэсэн дүнгийн тухай Г

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.3 дахь заалт, Компанийн дүрмийн 6 дугаар зүйлийн 6.1.10-6.1.16 дахь заалтыг тус тус удирдлага болгон 2025 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын санал хураалтын дүнг нэгтгэн тоолсныг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Нийт **89.06** хувийн саналын эрхтэй **694,791,015** ширхэг хувьцааны **654** ширхэг саналын хуудас хураасныг тооцсугай.
2. 2025 оны 04-р сарын 25-ны өдөр санал хураах хайрцгаар **87.35** хувийн саналын эрхтэй **681,449,159** ширхэг хувьцааны **91** ширхэг саналын хуудас хураасныг дурдсугай.
3. Урьдчилж ирүүлсэн саналын хуудасны хувьд, цахим хаягаар дамжуулж **0.00** хувийн саналын эрхтэй **200** ширхэг хувьцааны **1** ширхэг саналын хуудас, компанийн байранд **1.71** хувийн саналын эрхтэй **13,341,656** ширхэг хувьцааны **562** ширхэг саналын хуудас тус тус урьдчилж ирүүлснийг дурдсугай.
4. Нийт саналын хуудаснаас **0.01** хувийн саналын эрхтэй **116,314** ширхэг хувьцааны **96** ширхэг саналын хуудас хүчингүй болсныг дурдсугай.
5. Говь ХК-ийн 2024 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайлангийн талаар Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс өгсөн дүгнэлтийг хуралд оролцогчдын саналын эрхийн олонхоор буюу **99.99** хувийн саналаар баталсныг мэдэгдсүгэй.
6. Компанийн дүрэмд оруулах нэмэлт, өөрчлөлтийг батлах тухай асуудлыг хуралд оролцогчдын саналын эрхийн олонхоор буюу **99.99** хувийн саналаар баталсныг мэдэгдсүгэй.

7. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2025 оны цалингийн төсвийг батлах тухай асуудлыг хуралд оролцогчдын саналын эрхийн олонхоор буюу **99.99** хувийн саналаар баталсныг мэдэгдсүгэй.
8. Говь ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус болон ердийн гишүүдийг сонгох асуудлаар хувьцаа эзэмшигчдийн өгсөн саналыг кумулятив аргаар тоолж, хамгийн олон санал авсан 9 гишүүдийг сонгон томилсныг мэдэгдсүгэй.

ТООЛЛОГЫН КОМИССЫН ДАРГА

КОМИССЫН ГИШҮҮД

КОМИССЫН НАРИЙН БИЧИГ



Н.САЙНЗУЛ

Ц.ЦЭЦЭГБАДАМ

Б.УЯНГА

Б.УРАНГОО

Г.УУГАНЗАЯА

Д.САРАНГУА



**“ГОВЬ” ХУВЬЦААТ КОМПАНИ
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ
ХУРЛЫН ТОГТООЛ**

2025 оны 04 сарын 25 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

Г Компанийн 2024 оны санхүүгийн болон үйл
ажиллагааны тайланд өгөх ТУЗ-ийн дүгнэлтийг
батлах тухай 7

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт, Компанийн дүрмийн 6 дугаар зүйлийн 6.1.9.10 дахь заалтуудыг тус тус удирдлага болгон Говь ХК-ийн 2024 оны санхүүгийн болон жилийн үйл ажиллагааны тайлантай танилцаж, Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс компанийн үйл ажиллагаанд өгсөн дүгнэлтийг хэлэлцсэний үндсэн дээр 2025 оны 04-р сарын 25-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Говь ХК-ийн 2025 оны санхүүгийн болон жилийн үйл ажиллагааны тайланд Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс өгсөн дүгнэлтийг Хавсралт 1 ёсоор баталсугай.

ХУРЛЫН ДАРГА



Д.ГЭРЭЛМАА



ГОВЬ ХК-ИЙН 2024 ОНЫ САНХҮҮГИЙН БОЛОН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАНД ӨГӨХ ДҮГНЭЛТ

Монгол Улсын Компанийн тухай хууль болон Говь ХК-ийн дүрмийн хүрээнд тус компанийн 2024 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайланд өгөх дүгнэлтийг 2025 оны 3-р сарын 20-ны Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ)-ийн хурлаар хэлэлцэж, Хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулж байна.

ТУЗ нь компанийн 2024 оны бизнес төлөвлөгөө болон үйл ажиллагааны зорилтуудыг баталж, хэрэгжилтийн явцад тогтмол хяналт тавьж, Гүйцэтгэх удирдлагын багийг шаардлагатай санал зөвлөмж, үүрэг даалгавраар ханган чиглүүлж ажилласан. Гүйцэтгэх удирдлагын баг нь батлагдсан төлөвлөгөө, зорилт, шийдвэр, үүрэг даалгаврыг хэрэгжүүлэхийн төлөө хүчин чармайлт, тууштай хичээл зүтгэл гаргасныг ТУЗ-ийн зүгээс онцлон тэмдэглэж байна.

ТУЗ-ийн баталсан 2024 оны бизнес төлөвлөгөө болон үйл ажиллагааны зорилт нь компанийн борлуулалтын орлогыг өмнөх жилтэй ижил түвшинд барьж ашигт ажиллагааг сайжруулах, брэндийн цогц шинэчлэлтийг хийх, Төв дэлгүүрийн өнгө төрхийг иж бүрэн шинэчлэх, POS шинэ системийг нэвтрүүлэн урамшууллын системийг ашиглах, нөөцийн удирдлагыг сайжруулах, программ хангамж болон удирдлагын системүүдийг дараагийн түвшинд хөгжүүлэн ашиглаж эхлэх, бэлчээрийн доройтлын эсрэг төслийг өргөжүүлэх, хүний нөөцийн тогтворжилтыг хангаж байгууллагын соёлыг сайжруулах төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх, Говь академи байгуулах, залгамж халааг бэлтгэх замаар ур чадварыг системтэй хөгжүүлэх, бүтээгдэхүүний загвар дизайныг хөгжүүлж, нэр төрлийг нэмэгдүүлэх, бэлэн бүтээгдэхүүнд ОЕКО TEX-100 гэрчилгээ авах зэрэгт тус тус чиглэсэн билээ.

Санхүүгийн үр дүнгийн хувьд, өнгөрөгч 2024 онд 247.0 тэрбум төгрөгийн борлуулалт хийж бизнес төлөвлөгөөний биелэлт 98% байлаа. Дотоод борлуулалт 163.4 тэрбум төгрөг буюу төлөвлөгөөний биелэлт 103%, гадаад борлуулалт 25.7 тэрбум төгрөг буюу төлөвлөгөөний биелэлт 93%, экспортын борлуулалт 57.9 тэрбум төгрөг буюу төлөвлөгөөний биелэлт 88% байв. 2024 онд өмнөх онтой харьцуулахад алдагдлын хэмжээг 46% бууруулж 3.7 тэрбум төгрөгийн алдагдалтай ажилласан бөгөөд ашигт ажиллагааны гүйцэтгэлийг 2023 онтой харьцуулахад үйл ажиллагааны ашгийн хувь 1 пунктээр, EBITDA хувь 2 пунктээр, цэвэр ашгийн хувь 2 пунктээр тус бүр сайжирсан. Мөн өр төлбөр/EBITDA харьцаа сайжирч 5.7 болсон. Түүнчлэн түүхий эдийн татан авалтыг хамгийн бага түвшинд хийж, нөөцөө бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлснээр бараа материалын эргэц хоног 2023 оноос 5%-аар буурч 358 хоног болж сайжирсан байна.

2024 онд маркетингийн зардлыг 66%-аар бууруулж, нийт 9.4 тэрбум төгрөгийг зарцуулсан. Гадаад зах зээлийн маркетингийн зардлыг өмнөх оноос 70%-аар бууруулж 7.9 тэрбум төгрөгийг зарцуулсан нь нийт маркетингийн зардлын 83%-ийг эзэлж байна. Охин компанийн ашигт ажиллагааг сайжруулах хүрээнд хямдралын хувийг 7.1 пунктээр бууруулсан ба гадаад зах зээлийн ROAS буюу 1 төгрөгийн маркетингийн зардлаас олж буй орлогын дүн 4.2 төгрөг болж сайжирсан.

Үйлдвэрлэл ба бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн хувьд, 2024 онд 1 сая бүтээгдэхүүн үйлдвэрлэж төлөвлөгөөний биелэлт 106%, бүтээгдэхүүний чанарын үзүүлэлт 93% болж өмнөх оноос 1% өссөн. Мөн 1 сая ширхэг бүтээгдэхүүн борлуулж төлөвлөгөөний биелэлт 97% байв. Өнгөрөгч онд бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэн өнгөрөгч онд

бүтээгдэхүүний нэр төрлийг өргөжүүлж, ноолууран гутлын олон төрлийн шинэ загваруудаас гадна саравчтай малгай, цүнх, CashmereTECH дэвшилтэт технологийн ноолууран дүүргэлттэй куртка, ноолууран дотортой савхин бээлий, лаа гэх мэт шинэ бүтээгдэхүүнүүдийг зах зээлд нэвтрүүлж, ноолуурын хэрэглээний цар хүрээг зогсолтгүй өргөжүүллээ. Түүнчлэн, олон улсын "OEKO-TEX STANDARD 100" гэрчилгээг Монголд анх удаа бэлэн бүтээгдэхүүн дээр гардан авав.

Мөн Ерөнхий дизайнераар Италийн алдарт дизайнер Giorgio Spina үргэлжлүүлэн ажиллан Тогтвортой ноолуур 3 талт төслийн хүрээнд CashmeReborn, Responsible Cashmere коллекц, GOBI ба GOBI Organic FW24/25, SS25, FW25/26 зэрэг ноолууран бүтээгдэхүүний загварыг шинэ түвшинд хүргэсэн коллекцуудыг танилцуулав.

Борлуулалтын зах зээлүүдийн хувьд, дотоод борлуулалтыг дэмжих зорилгоор үнэнч хэрэглэгчдэд зориулсан урамшууллын хөтөлбөрийг нэвтрүүлж, Flagship Store буюу үйлдвэрийн дэргэдэх төв дэлгүүрийг Монгол нутгийн онцлогийг шингээсэн орчин үеийн хэв маягтайгаар өнгө төрхийг бүрэн шинэчилж, хэрэглэгчдэд илүү ая тухтай үйлчилгээний орчин бүрдүүлсэн. Мөн гадаад зах зээлд 2024 онд маркетингийн стратегиа өөрчлөн, органик өсөлт, брэндийн үнэлэмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн маркетинг хийж, ашигт ажиллагааг сайжруулахад төвлөрч ажилласан.

Компанийн программ хангамж болон удирдлагын системийн хувьд, бизнесийн үйл ажиллагааг автоматжуулж, ажлын гүйцэтгэлийг хурдасгах, бүтээмжийг нэмэгдүүлэх зорилгоор системийн шинэчлэлтийг дараагийн түвшинд гаргаж, нийт компанийн хэмжээнд SAP S/4 HANA Enterprise Resource Management (ERP) систем, RFID системийг үйл ажиллагаандаа амжилттай нэвтрүүлэн ашиглаж эхэлсэн. Мөн Монгол Улсын хөнгөн аж үйлдвэрийн салбарын түүхэнд анх удаа үйлдвэрлэл гүйцэтгэлийн систем (Manufacturing Execution System) болон дамжлагын систем (Conveyor Belt)-ийг нэвтрүүлэн ашиглаж эхэлсэн ба эдгээр системүүд нь үйлдвэрлэлийн үр ашиг, бүтээмжийг нэмэгдүүлэх, процессыг сайжруулах, санхүүгийн удирдлага, шийдвэр гаргалтыг оновчтой бөгөөд хурдан хийх боломжийг бүрдүүлэх юм.

Тогтвортой хөгжлийн үйл ажиллагааг хөгжүүлэх зорилгоор, тогтвортой хөгжлийн цогц бодлогыг боловсруулж эхлэн, мэргэжлийн хараат бус зөвлөх компанитай хамтран ТУЗ болон менежмент багийн түвшинд шат дараалсан сургалт, уулзалтуудыг зохион байгуулж Тогтвортой хөгжлийн стратегийн бодлого боловсруулж, уур амьсгалын өөрчлөлт, хүний эрх, жендерийн тэгш байдал, нийгмийн хариуцлагын чиглэлээр бодлогуудаа тодорхойлон баталсан. Мөн "Тогтвортой ноолуур, гурван талт хамтарсан төсөл"-ийн үндсэн үйл ажиллагаанд тулгуурлан Азийн Хөгжлийн Банкны санхүүжилтээр уур амьсгалын өөрчлөлтөд малчдыг бүлгэмээр дасан зохицуулах, бэлчээрийн тогтвортой менежментийг бий болгох туршилтын төслийг хэрэгжүүлж эхлэв.

Хүний нөөцийн тогтворжилтыг хангаж байгууллагын соёлыг сайжруулах зорилгоор, ажилтнуудын хүүхдүүдийн "Говийн багачууд цэцэрлэг" 3 дахь жилдээ амжилттай ажилласан ба Говь академийг байгуулж давтагдсан тоогоор 2,000 орчим ажилтанд дотоод сургалт орсон байна. Мөн ажилтнуудын сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх, ажлын байрны орчин нөхцөлийг сайжруулах ажлуудыг шат дараатай хэрэгжүүллээ.

Өнгөрөгч онд хэрэгжүүлсэн онцлох ажлуудаас дурдвал, Говь ХК-ийг дэлхийн зах зээлд илүү өргөн хүрээнд таниулж, олон улсын түвшинд өрсөлдөхүйц компани болох зорилгоор Rebranding буюу брэндийн цогц шинэчлэлтийг хийснээр GOBY брэнд анх удаа бэлгэ

тэмдэгтэй болж, шинэчилсэн лого ба шинэ өнгө төрхтэйгөөр дотоод болон гадаадын зах зээлд бүтээгдэхүүнээ хүргэж байна. Мөн хүний нөөцийн салбарын чуулган болох Mongolian Labor Market Summit: Good Workplace Awards 2024 арга хэмжээний үеэр “Эмэгтэйчүүдийн карьерын өсөлтийг дэмжигч шилдэг ажил олгогч”-оор шалгарсан нь 70 гаруй хувь нь эмэгтэй ажилтнуудаас бүрддэг манай компанийн хувьд ажилтнуудынхаа хөгжлийг дэмжих, тэгш боломжийг хангах бодлогын хэрэгжилтийг улам бүр бататгасан үнэ цэнтэй шагнал боллоо.

Дээр дурдсан үр дүнд үндэслэн Говь ХК-ийн Гүйцэтгэх удирдлагын баг нь 2024 онд шинэ удирдлагатайгаар төлөвлөсөн зорилтоо биелүүлэхийн тулд өөрсдийн нөөц бололцоогоо бүрэн дүүрэн ашиглаж, компанийн урт хугацааны тогтвортой өсөлтийг хангахын төлөө оновчтой бодлого хэрэгжүүлэн ажилласан гэж **Төлөөлөн удирдах зөвлөлөөс дүгнэж байна.**

**ГОВЬ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ**



**“ГОВЬ” ХУВЬЦААТ КОМПАНИ
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ
ХУРЛЫН ТОГТООЛ**

2025 оны 04 сарын 25 өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

Г
Компанийн дүрэмд оруулах нэмэлт, өөрчлөлтийг
батлах тухай
Г


Монгол Улсын Компанийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 62 дугаар зүйлийн 62.1.1, Компанийн дүрмийн 6 дугаар зүйлийн 6.1.9.1 дэх заалтуудыг тус тус удирдлага болгон 2025 оны 04-р сарын 25-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Говь ХК-ийн дүрэмд оруулах нэмэлт, өөрчлөлтийг Хавсралт 1-ээр баталсугай.
2. Говь ХК-ийн шинэчлэн найруулсан дүрмийг Хавсралт 2-оор баталсугай.
3. Компанийн дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг тусгасан шинэчлэн найруулгыг хуульд заасан журмын дагуу Улсын бүртгэлд итгэмжлэлгүйгээр төлөөлөн бүртгүүлэхийг Хуулийн хэлтсийн дарга /Ц.Цасчихэр/-т даалгасугай.
4. Компанийн дүрэмд оруулсан нэмэлт, өөрчлөлт, шинэчлэн найруулсан дүрмийг Улсын бүртгэл бүртгэсэн өдрөөс эхлэн үйл ажиллагаандаа дагаж мөрдөн, хэрэгжилтийг ханган ажиллахыг Гүйцэтгэх захирал /Б.Амарсайхан/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Д.ГЭРЭЛМАА



ГОВЬ ХК-ИЙН ДҮРЭМД ОРУУЛАХ НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ

№	Одоогийн дүрмийн заалт	Шинэчилсэн заалт	Тайлбар
1	-	Арван нэг. Ахмадын сангийн тухай 11.1 Компани нь ажиллаж байсан ахмад настанд Ахмад настны тухай хуулийн 14.6-д заасан арга хэмжээнд дэмжлэг үзүүлэх зорилгоор “Ахмадын сан” байгуулан ажиллуулна. 11.2 Ахмадын сангийн мөнгөн хөрөнгийн хэмжээг гүйцэтгэх удирдлага нь 2 жилд нэг удаа Үйлдвэрчний эвлэл болон түүний дэргэдэх Ахмадын хороотой хэлэлцэн тогтооно.	Шинээр нэмж оруулав.
2	Арван нэг. Дүрмийн нэмэлт, өөрчлөлт. 4.1.4 Компанийн ТУЗ нь шаардлагатай тохиолдолд энэхүү дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах болон шинэчилсэн найруулгыг хийх бол энэ талаар санал боловсруулан хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулж батлуулна. 4.1.2 Энэхүү дүрэм нь улсын бүртгэлд бүртгэгдсэн өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.	Арван хоёр. Дүрмийн нэмэлт, өөрчлөлт. 12.1 Компанийн ТУЗ нь шаардлагатай тохиолдолд энэхүү дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах болон шинэчилсэн найруулгыг хийх бол энэ талаар санал боловсруулан хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулж батлуулна. 12.2 Энэхүү дүрэм нь улсын бүртгэлд бүртгэгдсэн өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.	Дугаарлалт өөрчлөгдөв.
3	5.1 Компани гаргасан-энгийн хувьцааг-заавал-гаргах ба үүнээс гадна давуу эрхийн хувьцаа, өрийн бичиг, хувьцаанд хамаарах үнэт цаасыг нээлттэй ба хаалттай хэлбэрээр гаргаж болно.	5.1 Компани энгийн хувьцааг заавал гаргах ба үүнээс гадна давуу эрхийн хувьцаа, өрийн бичиг, хувьцаанд хамаарах үнэт цаасыг нээлттэй ба хаалттай хэлбэрээр гаргаж болно.	Найруулга засав.
4	6.1.12 Хувьцаа эзэмшигч өөрийн төлөөлөх этгээдийг бичгээр өлгөсөн итгэмжлэлийн үндсэн дээр хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцуулж болно. Төлөөлж оролцох этгээд энэ тухайгаа ТУЗ-д хурал эхлэхээс өмнө мэдэгдэнэ.	6.1.12 Хувьцаа эзэмшигч нь хувьцаа эзэмшигчдийн хуралд бичгээр, эсхүл цахим хэлбэрээр олгосон итгэмжлэлийн үндсэн дээр өөр этгээдээр төлөөлүүлэн оролцож болно. Төлөөлж оролцох этгээд энэ тухайгаа ТУЗ-д хурал эхлэхээс өмнө мэдэгдэнэ.	Өөрчлөлт оруулав.

5	6.2.8 ТУЗ-ийн ээлжит хурлыг 2 сард нэг удаа хуралдуулна. Шаардлагатай гэж үзвэл нэмэлт хуралдааныг хэдийд ч хийж болно. ТУЗ-ийн хурлын шийдвэр нь тогтоол байна. Тогтоолд ТУЗ-ийн дарга гарын үсэг зурж баталгаажуулна. ТУЗ-ийн хурлын тэмдэглэлийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга хөтлөх бөгөөд түүнд хуралд оролцсон бүх гишүүд өөрийн хэлсэн үг, гаргасан саналын үнэн зөвийг хянан гарын үсгээ зурна.	6.2.8 ТУЗ-ийн ээлжит хурлыг улиралд нэг удаа хуралдуулна. Шаардлагатай гэж үзвэл нэмэлт хуралдааныг хэдийд ч хийж болно. ТУЗ-ийн хурлын шийдвэр нь тогтоол байна. Тогтоолд ТУЗ-ийн дарга гарын үсэг зурж баталгаажуулна. ТУЗ-ийн хурлын тэмдэглэлийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга хөтлөх бөгөөд түүнд хуралд оролцсон бүх гишүүд өөрийн хэлсэн үг, гаргасан саналын үнэн зөвийг хянан гарын үсгээ зурна.	Өөрчлөлт оруулав.
6	7.1. ТУЗ-ийн Дарга, гишүүд, нарийн бичгийн дарга, компанийн Гүйцэтгэх захирал, дэд захирлууд, газрын захирлууд, хуулийн хэлтсийн дарга-зэрэг албан тушаалтныг компанийн эрх бүхий албан тушаалтанд тооцно.	7.1. ТУЗ-ийн дарга, гишүүд, нарийн бичгийн дарга, компанийн Гүйцэтгэх захирал, дэд захирлууд, газрын захирлууд зэрэг албан тушаалтныг компанийн эрх бүхий албан тушаалтанд тооцно.	Өөрчлөлт оруулав.
7	10.6 Татан буулгах комисс нь компанийг татан буулгах болон нэхэмжлэл гаргах хугацаа журмыг нийтэд болон зээлдүүлэгчид мэдээлнэ. Нэхэмжлэл гаргах хугацаа нь татан буулгах хугацаа нийтэд мэдээлснээс хойш 3-сар байна.	10.6 Татан буулгах комисс нь компанийг татан буулгах болон нэхэмжлэл гаргах хугацаа журмыг нийтэд болон зээлдүүлэгчид мэдээлнэ. Нэхэмжлэл гаргах хугацаа нь татан буулгах хугацааг нийтэд мэдээлснээс хойш хоёр сараас доошгүй, зургаан сараас дээшгүй байна.	Өөрчлөлт оруулав.
8	10.8 Нэхэмжлэл гаргах хугацаа дууссан өдрөөр тасалбар болгон компанийн эд хөрөнгө, эд хөрөнгийн эрх, зээлдүүлэгчдийн гаргасан нэхэмжлэлийн шаардлагын дүнг тусгасан шаардлагын дүнг тусгасан татан буулгах түр балансыг гаргах бөгөөд уг балансыг хувьцаа эзэмшигчдийн хурал батална.	10.8 Нэхэмжлэл гаргах хугацаа дууссан өдрөөр тасалбар болгон компанийн эд хөрөнгө, эд хөрөнгийн эрх, зээлдүүлэгчдийн гаргасан нэхэмжлэлийн шаардлагын дүнг тусгасан татан буулгах түр балансыг гаргах бөгөөд уг балансыг хувьцаа эзэмшигчдийн хурал батална.	Давхардсан хэсгийг засав.



ГОВЬ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ДҮРЭМ /Шинэчилсэн найруулга/

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Говь компани нь нээлттэй хувьцаат компани (ХК) (цаашид Компани гэх) мөн.
- 1.2. Монгол улсын Иргэний хууль, Компанийн тухай хууль, бусад холбогдох хууль болон энэхүү дүрмээр компанийн үйл ажиллагааг зохицуулна.
- 1.3. Компанийн оноосон албан ёсны нэрийг:
 - 1.3.1 Монголоор: **Говь Хувьцаат компани (ХК)**
 - 1.3.2 Англиар: **Gobi Corporation (JOINT STOCK COMPANY)** гэнэ.
- 1.4. Компанийн оршин байгаа газрын хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 3-р хороо, үйлдвэрийн гудамж, өөрийн байр
- 1.5. Компани нь хуулийн этгээдийн бүрэн эрхийг хэрэгжүүлэх, үйл ажиллагаа явуулах, гэрээ хэлцэл хийх зэрэг бүх тохиолдолд Говь ХК гэсэн тэмдэглэгээг хэрэглэнэ.
- 1.6. Компани Төлөөлөн Удирдах Зөвлөл (цаашид ТУЗ гэх)-ийн шийдвэрээр салбар, төлөөлөгчийн газар, хараат болон охин компани байгуулж болно.
- 1.7. Компани өөрийн албан бичгийн хэвлэмэл хуудас, тэмдэгтэй байна.
- 1.8. Компани өөрийн билэгдэл, барааны тэмдэгтэй байх бөгөөд түүний загварыг ТУЗ баталж, Оюуны өмчийн газар бүртгүүлсэн байна. Компанийн билэгдэл, барааны тэмдгийг хэрэглэх эрхийг зөвхөн Говь ХК эдэлнэ.

Хоёр. Компанийн эрхэм зорилго, үйл ажиллагааны үндсэн чиглэл

- 2.1. Хэрэглэгчийн эрэлт хэрэгцээнд нийцсэн, зах зээлд өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүн үйлдвэрлэж, худалдах замаар хувьцаа эзэмшигчдийн ашиг сонирхлыг эрхэмлэж ажиллах нь компанийн эрхэм зорилго мөн.
- 2.2. Компанийн үйл ажиллагааны үндсэн чиглэл нь:
 - 2.2.1 Компани нь ямааны ноолуур, тэмээний ноос болон түүнтэй ижил төстэй түүхий эдээр өрсөлдөх чанарын хагас болон бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэн, гадаад дотоод зах зээлд шууд болон дамжуулан худалдах, эдгээр ажиллагаатай холбогдсон техник төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл, материал импортлох;
 - 2.2.2 Компани өөрөө буюу өөр байгууллагатай хамтран худалдаа, үйлчилгээ явуулах, нэрийн барааны дэлгүүр, үйлчилгээний салбар, нэгжийг ажиллуулах;
 - 2.2.3 Компани дотоод, гадаадын байгууллага, компаниудтай хорших, техник технологи, мэдээлэл, мэргэжилтэн, ажилчид солилцох, хамтран ажиллах, хамтарсан үйлдвэрлэл зохион байгуулах, бусад зуучлах зэрэг хамтын ажиллагааны ашигтай бүх хэлбэрийг сонгон хэрэглэх;
 - 2.2.4 Хуулиар хориглоогүй бусад ажил, үйлдвэрлэл үйлчилгээг ТУЗ-ийн зөвшөөрснөөр явуулж болно.

Гурав. Компанийн хувьцаа ба хувь нийлүүлсэн хөрөнгө

- 3.1 Компанийн зарласан болон гаргасан хувьцаа нь нэг бүр нь 1 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий **780,112,500** (долоон зуун наян сая нэг зуун арван хоёр мянга таван зуун) ширхэг энгийн хувьцаанаас бүрдэнэ. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нь **780,112,500** төгрөг байна.
- 3.1 Компани давуу эрхийн хувьцаа гаргаж болно. Давуу эрхийн хувьцааны тоо, нэрлэсэн үнэ, зориулалт, тухайн төрлийн хувьцаа эзэмшигчдэд олгох давуу эрх, тэдний хувьцаа эзэмшигчдийн хуралд саналын эрхтэй оролцох нөхцөл зэргийг уг хувьцааг гаргах тухай шийдвэрт заана.

3.2 Гаргасан хувьцааны төлбөрийг мөнгөн бус хэлбэрээр хийж болох бөгөөд энэ тохиолдолд хувьцааны төлбөрт хүлээн авч байгаа эд хөрөнгө, эд хөрөнгийн эрх, оюуны өмчийн үнэлгээг эрх бүхий үнэлгээний байгууллагын дүгнэлтийг үндэслэн ТУЗ тогтооно.

Дөрөв. Хувьцаа эзэмшигчдийн эрх, үүрэг, хариуцлага

4.1. Компанийн энгийн хувьцааг худалдан авч эзэмшсэн этгээд компанийн хувьцаа эзэмшигч байна.

4.2. Энгийн хувьцаа эзэмшигч нь дараахь эрх эдэлнэ:

4.2.1 Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурал зарлах үед ТУЗ-өөс тогтоосон бүртгэлийн өдөр компанийн хувьцааг эзэмшиж байсан этгээд хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож, хэлэлцэж буй бүх асуудлаар өөрийн эзэмшиж буй саналын эрхтэй хувьцаатай хувь тэнцүүлэн санал өгөх эрхтэй:

4.2.2 ТУЗ-өөс ногдол ашиг олгохоор шийдвэрлэсэн үед давуу эрхийн хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилсны дараа эзэмшиж буй хувьцаанд ногдох ногдол ашиг авах, ногдол ашиг олгохоор зарласан боловч хууль, журамд заасан хугацаандаа компанийн буруутай үйл ажиллагаанаас болж олгохгүй бол алданги төлөхийг шаардах эрхтэй:

4.2.3 Компанийг татан буулгах үед компанийн тухай хуульд заасан журмын дагуу өр төлбөрийг барагдуулсны дараа үлдсэн эд хөрөнгийг худалдсанаас олсон орлогоос эзэмшиж буй хувьцаанд ногдох хувь хэмжээгээр хувь хүртэх эрхтэй:

4.2.4 Компаниас нэмж гаргасан хувьцаа, хувьцаанд хөрвөх үнэт цаасыг тэргүүн ээлжид худалдан авах

4.3 Хувьцаа эзэмшигчдийн хурлаар доорх асуудлаар шийдвэр гаргахад эсрэг саналтай байсан, эсвэл санал хураалтад оролцоогүй хувьцаа эзэмшигч бүр өөрийн эзэмшиж буй хувьцааг компанид эргүүлэн авахыг шаардах эрхтэй. Үүнд:

4.3.1 Нийлэх, нэгдэх, хуваах болон хязгаарлагдмал хариуцлагатай компани болгон өөрчлөх:

4.3.2 Их хэмжээний хэлцэл хийх:

4.3.3 Компанийн хувьцаа эзэмшигчдийн эрхийг хязгаарласан нэмэлт өөрчлөлтийг оруулсан эсвэл ийм агуулгатай компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах:

4.4 Хувьцаа эзэмшигч дангаараа эсвэл түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдийн хамт компанийн энгийн хувьцааны 75-аас дээш хувийг эзэмших тохиолдолд бусад хувьцаа эзэмшигчид нь компанид хувьцаагаа эргүүлэн авахыг шаардах эрхтэй. Эргүүлэн авах хувьцааны үнийг хөрөнгийн биржийн арилжааны сүүлийн 6 сарын дундаж ханшийг үндэслэн ТУЗ тогтооно. Тэгэхдээ Компанийн тухай хуулийн холбогдох заалтыг үндэслэл болгоно.

4.5 Энгийн хувьцааны 5 буюу түүнээс дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигч нь хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамаарах асуудлаар болон ТУЗ, тооллогын комиссын гишүүнд нэр дэвшүүлэх хүний талаарх саналаа хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын хэлэлцэх асуудлын жагсаалтад оруулахаар өмнөх санхүүгийн жил дууссанаас хойш 60 хоногийн дотор ТУЗ, эсхүл гүйцэтгэх удирдлагад гаргаж болно.

4.6 Компанийн нийт гаргасан хувьцааны 5-аас дээш хувийг дангаараа болон бусадтай хамтран эзэмшсэн этгээд өмчлөх эрх үүссэнээс хойш 30 хоногийн дотор компанид бичгээр мэдэгдэх үүрэгтэй. Ийнхүү мэдэгдэл ирүүлэх нь компанийн хувьцаа эзэмшигчдийн хуралд асуудал хэлэлцүүлэхээр оруулах тухай энэ дүрмийн 4.5-д заасан эрхээ эдлэх баталгаа болно.

4.7 Компани хувьцаа эзэмшигчдийн өмнөөс хариуцлага хүлээхгүй.

4.8 Хувьцаа эзэмшигч нь компанийн хүлээх үүргийг хариуцахгүй бөгөөд гагцхүү эзэмшиж байгаа хувьцааны хэмжээгээр хариуцлага хүлээнэ.

4.9 Хувьцаа эзэмшигч нь өөрийн буруутай үйл ажиллагааны улмаас компанид учруулсан эд хөрөнгийн хохирлыг өөрийн хөрөнгөөр компанийн өмнө хариуцна.

4.10 Хувьцаа эзэмшигчдийн компанид оруулсан эд хөрөнгө, эд хөрөнгийн эрх нь хувийн эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхээс тодорхой зааглагдаагүй бол уг хувьцаа эзэмшигч өөрийн бүх эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхээр компанийн өр төлбөрийг давхар хариуцна.

Тав. Компани үнэт цаасыг гаргах, худалдах, эргүүлэн авах

- 5.1 Компани энгийн хувьцааг заавал гаргах ба үүнээс гадна давуу эрхийн хувьцаа, өрийн бичиг, хувьцаанд хамаарах үнэт цаасыг нээлттэй ба хаалттай хэлбэрээр гаргаж болно.
- 5.2 Үнэт цаасыг нийтэд санал болгон худалдахаар шийдвэрлэсэн бол Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн дагуу гүйцэтгэнэ.
- 5.3 Компанийн өрийг хувьцаагаар солих, хувьцаа нэмж гаргах, түүнийг тоог Хувьцаа эзэмшигчдийн хурлаар шийдвэрлэнэ. ТУЗ-өөс энэхүү асуудлаар хувьцаа эзэмшигчдийн хуралд санал оруулж болно.
- 5.4 Компанийн өөрийн хөрөнгийн хэмжээгээр барьцаалан өрийн бичиг гаргах асуудлыг ТУЗ шийдвэрлэнэ. ТУЗ-ийн шийдвэрт гаргах өрийн бичгийн тоо, нэрлэсэн үнэ, зориулалт, хүүгийн хэмжээ, хүү төлөх хугацаа, эргэж төлөгдөх хугацаа, эргүүлэн авах үнэ, энгийн хувьцаанд хөрвөх эсэхийг заасан байна.
- 5.5 Компани өөрийн гаргасан үнэт цаасыг эзэмшигчидтэй нь тохиролцсоны үндсэн дээр худалдан авч болно. Компани энгийн хувьцаанаас бусад үнэт цаасыг бүхэлд нь эсхүл зарим хэсгийг худалдан авч болно. Харин энгийн хувьцааны хувьд тухайн жилд гүйлгээнд байсан нийт хувьцааны дунджийн 25 хувиас илүүгүй байна.
- 5.6 Компани өөрийн гаргасан үнэт цаасыг худалдаж авах шийдвэрийг энгийн хувьцааны 5-аас дээш хувийг худалдаж авахаас бусад тохиолдолд ТУЗ гаргах бөгөөд уг шийдвэртээ худалдаж авах үнэт цаасны төрөл, тоо, үнэ, төлбөр хийх хугацаа, ашиглах журам зэргийг заана.

Зургаа. Компанийн удирдлага

6.1 Хувьцаа эзэмшигчдийн хурал

- 6.1.1 Компанийн эрх барих дээд байгууллага нь хувьцаа эзэмшигчдийн хурал байна.
- 6.1.2 Хувьцаа эзэмшигчдийн хурал нь ээлжит ба ээлжит бус байна.
- 6.1.3 Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг санхүүгийн жил дууссанаас хойш 4 сарын дотор ТУЗ зарлан хуралдуулна.
- 6.1.4 Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах тухай шийдвэрийг ТУЗ гаргах ба уг шийдвэрт дараах асуудлыг заавал тусгана. Үүнд:
 - 6.1.4.1 хурал хуралдуулах газар, өдөр, цаг
 - 6.1.4.2 хурлаар хэлэлцэх асуудал
 - 6.1.4.3 хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр
 - 6.1.4.4 хурал хуралдуулах тухай хувьцаа эзэмшигчдэд мэдэгдэх өдөр, журам
 - 6.1.4.5 хуралд бэлтгэх явцад хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох баримт бичгийн жагсаалт
 - 6.1.4.6 саналын хуудасны агуулга
 - 6.1.4.7 саналын хуудсыг хүлээн авах сүүлчийн өдөр
 - 6.1.4.8 хурлын дарга
 - 6.1.4.9 тооллогын комиссын дарга, гишүүд
- 6.1.5 Хувьцаа эзэмшигчдийн хурлыг дээрх шийдвэрийг гаргаснаас хойш 40-өөс доошгүй хоногийн дараа хуралдуулна.
- 6.1.6 Энэ тухай шийдвэр гаргаснаас хойш 5 хоногийн дотор хурлын зарыг компани нийтэд мэдээлнэ.
- 6.1.7 Дор дурдсан тохиолдолд ТУЗ хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг хуралдуулах тухай шийдвэр гаргана. Үүнд:
 - 6.1.7.1 ТУЗ-ийн нийт гишүүдийн талаас дээш хувь нь ажиллах боломжгүй буюу ажиллахгүй болсон\
 - 6.1.7.2 ТУЗ-ийн 2 буюу түүнээс дээш тооны хараат бус гишүүн, саналын эрхтэй хувьцааны 10 буюу түүнээс дээш хувийн хувьцаа эзэмшигч санал, шаардлага гаргасан
 - 6.1.7.3 Компанийн алдагдал тухайн тайлант үеийн эцэст өөрийн хөрөнгийн 30 хувиас хэтэрсэн
 - 6.1.7.4 Компанийн өр нь өөрийн хөрөнгөөс 2 жил дараалан илүү болж, хасах утгатай болсон
 - 6.1.7.5 ТУЗ шийдвэр гаргасан

- 6.1.7.6 Аудитын хорооноос ээлжит бус хурал хийхийг шаардсан
- 6.1.8 Хурал зарласнаас хойш хурлын хэлэлцэх асуудалд өөрчлөлт оруулахыг хориглоно.
- 6.1.9 Дор дурдсан асуудлыг хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэнэ. Үүнд:
- 6.1.9.1 Компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах буюу шинэчилсэн найруулгыг батлах;
- 6.1.9.2 Нийлэх, нэгдэх, хуваах буюу өөрчлөх хэлбэрээр компанийг өөрчлөн байгуулах;
- 6.1.9.3 Компанийн өрийг хувьцаагаар солих,
- 6.1.9.4 Компанийн хэлбэрийг өөрчлөх;
- 6.1.9.5 Компанийг татан буулгах болон татан буулгах комиссыг томилох;
- 6.1.9.6 Хувьцааг хуваах ба нэгтгэх;
- 6.1.9.7 Компанийн зарласан хувьцааны төрөл болон хэмжээнд багтаан хувьцаа нэмж гаргах;
- 6.1.9.8 ТУЗ-ийн гишүүдийг сонгох, бүрэн эрхийг нь хугацаанаас нь өмнө дуусгавар болгох;
- 6.1.9.9 Хувьцаа эзэмшигчдэд үнэт цаасыг тэргүүн ээлжинд худалдан авах эрх эдлүүлэх эсэх;
- 6.1.9.10 Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах;
- 6.1.9.11 Их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцлийг хийх тухай шийдвэрийг ТУЗ гаргаж чадаагүй тохиолдолд түүнийг шийдвэрлэх
- 6.1.9.12 ТУЗ-ийн тухайн жилийн төсвийг батлах, ТУЗ-ийн гишүүдэд олгох хөлс, урамшууллын хэмжээг тогтоох, тайланг хэлэлцэх;
- 6.1.9.13 ТУЗ-ийн шийдвэрээр хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэхээр оруулсан бусад асуудал.
- 6.1.10 Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудлыг шийдвэрлэхэд нэг энгийн хувьцаа нэг саналын эрхтэй байна.
- 6.1.11 ТУЗ-ийн гишүүдийг сонгоход санал хураах кумулятив аргыг хэрэглэнэ.
- 6.1.12 Хувьцаа эзэмшигч нь хувьцаа эзэмшигчдийн хуралд бичгээр, эсхүл цахим хэлбэрээр олгосон итгэмжлэлийн үндсэн дээр өөр этгээдээр төлөөлүүлэн оролцож болно. Төлөөлж оролцох этгээд энэ тухайгаа ТУЗ-д хурал эхлэхээс өмнө мэдэгдэнэ.
- 6.1.13 Төлөөлөх тухай итгэмжлэл нь гагцхүү хувьцаа эзэмшигчдийн тухайн хуралд хүчинтэй. Хувьцаа эзэмшигчдийн хурал хойшилсон боловч тухайн хурлаар хэлэлцэхээр товлосон асуудал өөрчлөгдөөгүй тохиолдолд итгэмжлэл дараагийн хуралд хүчинтэй хэвээр байна.
- 6.1.14 Саналын эрхийн 51-ээс дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид оролцсоноор хувьцаа эзэмшигчдийн хурал хүчин төгөлдөр болно.
- 6.1.15 Хувьцаа эзэмшигчдийн хурлаас гарах шийдвэрийн төсөлд бичгээр санал ирүүлсэн тохиолдолд түүнийг хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцсон гэж үзнэ. Харин ээлжит бус хуралд хувьцаа эзэмшигчид заавал биечлэн буюу итгэмжлэлээр оролцоно.
- 6.1.16 Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1- 62.1.6-д заасан асуудлыг хуралд оролцож байгаа саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн саналын эрхийн дийлэнх олонхоор, хууль болон энэ дүрэмд өөрөөр заагаагүй бол бусад асуудлаар хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцогчдын саналын олонхоор гаргасан шийдвэр хүчин төгөлдөр байна.
- 6.1.17 Хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэлийг Компанийн тухай хуульд заасан журмын дагуу хөтөлж, баталгаажуулан хадгална.
- 6.1.18 Компанийн тухай хуулийн 61.1.2-т заасан этгээд хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал хуралдуулах тухай санал, шаардлагыг ТУЗ-д гаргах эрхтэй.
- 6.1.19 Компанийн тухай хуулийн 61.2-т заасан санал шаардлагыг бичгээр гаргах бөгөөд түүнд санал, шаардлага гаргасан хувьцаа эзэмшигчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, ээлжит бус хурал хуралдуулах болсон шалтгаан, хэлэлцэн шийдвэрлэх

асуудал, хурлаас гаргах шийдвэрийн төсөл, өөрийн эзэмшиж байгаа хувьцааны төрөл, тоог заана.

- 6.1.20 Хувьцаа эзэмшигчдийн хурал, түүний шийдвэрийн талаар хуралд оролцоогүй, эсхүл оролцсон боловч эсрэг саналтай байсан хувьцаа эзэмшигч шүүхэд гомдол гаргаж болно.

6.2 Төлөөлөн удирдах зөвлөл

- 6.2.1 Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт компанийн эрх барих байгууллага нь төлөөлөн удирдах зөвлөл \цаашид ТУЗ гэх\ байна.
- 6.2.2 ТУЗ нь 9 буюу түүнээс дээш гишүүнтэй байх ба тэдгээрийн гуравны нэгээс доошгүй нь хараат бус гишүүн байна.
- 6.2.3 ТУЗ-ийн гишүүн мэргэшил, ёс зүйн өндөр шаардлага хангасан, ял шийтгэлгүй, компанийн эрх ашгийг тэргүүн ээлжинд эрхэмлэдэг этгээд байвал зохих бөгөөд ТУЗ-ийн дарга, гишүүд нь компанийн өдөр тутмын ажилд оролцохгүйгээр, гагцхүү ТУЗ-ийн шийдвэр гарган мөрдүүлэн, хэрэгжилтэд нь хяналт тавих журмаар үйл ажиллагаагаа явуулна. ТУЗ-ийн гишүүний бүрэн эрхийн хугацаа 3 жил байна.
- 6.2.4 ТУЗ-ийн дарга орон тооны байж болно. ТУЗ-ийн даргыг ТУЗ-ийн гишүүд дундаасаа сонгоно.
- 6.2.5 Хувьцаа эзэмшигчдийн хурлаас хараат бус гишүүнийг ТУЗ-д сонгож чадаагүй тохиолдолд ТУЗ нь бүрэн эрхээ хэрэгжүүлэх чадваргүйд тооцогдоно. Дээр дурдсан нөхцөл үүссэн тохиолдолд ТУЗ нь хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдсанаас хойш ажлын 5 өдөрт багтаан дараагийн хувьцаа эзэмшигчдийн хурлын товыг тогтоож, ТУЗ-ийн гишүүдийг сонгох асуудлыг дахин хэлэлцүүлнэ.
- 6.2.6 ТУЗ-ийн гишүүн болон ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь компанийн засаглалын чиглэлээр сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсан байна.
- 6.2.7 ТУЗ нь компанийн тухай хууль болон энэ дүрмээр хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамааруулснаас бусад дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:
- 6.2.7.1 Компанийн үйл ажиллагааны үндсэн чиглэлийг тогтоох;
- 6.2.7.2 Компанийн жил бүрийн бизнес төлөвлөгөө ба түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлах;
- 6.2.7.3 Хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах тухай шийдвэр гаргах
- 6.2.7.4 Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудал, саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийг тодорхойлох бүртгэлийн өдөр болон хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулахтай холбогдсон бусад асуудлыг шийдвэрлэх;
- 6.2.7.5 Компанийн үйл ажиллагааны болон жилийн санхүүгийн тайлангийн талаарх дүгнэлт өгч хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулан батлуулах;
- 6.2.7.6 Компанийн тухай хуулийн 55-р зүйлд заасны дагуу эд хөрөнгийн болон эд хөрөнгийн эрхийн зах зээлийн үнийг тогтоох;
- 6.2.7.7 Компанийн нэр дэвшүүлэх хорооны ирүүлсэн саналыг үндэслэн Гүйцэтгэх захирлыг түүнтэй байгуулах гэрээний үндсэн дээр томилох, түүний бүрэн эрхийг тогтоох;
- 6.2.7.8 Компанийн Гүйцэтгэх захиралтай байгуулах гэрээний нөхцөл, олгох шагнал, урамшуулал, хариуцлагын хэмжээг тогтоох, гэрээнд компанийн санхүү эдийн засгийн үндсэн үзүүлэлтийн хүргэх төвшин, өртөг зардал, ашиг зэрэг асуудлуудыг тусгах;
- 6.2.7.9 Компанийн аудиторыг сонгож, түүнтэй хийх гэрээний нөхцөлийг тодорхойлох;
- 6.2.7.10 Ногдол ашгийн хэмжээ болон түүнийг төлөх журмыг тогтоох;
- 6.2.7.11 ТУЗ, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны болон компанийн засаглалын дотоод журмыг батлах;
- 6.2.7.12 Компанийн салбар болон төлөөлөгчийн газар байгуулах;
- 6.2.7.13 Компанийг өөрчлөн байгуулах талаар хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийн төслийг бэлтгэх, гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх;
- 6.2.7.14 Их хэмжээний хэлцэл хийх зөвшөөрөл олгох;

- 6.2.7.15 Сонирхлын зөрчил бүхий этгээдтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгох;
- 6.2.7.16 Эрх бүхий албан тушаалтнаас компанид учруулсан хохирлыг төлүүлэх хэмжээг тогтоох
- 6.2.7.17 Гадаад дотоодын байгууллага, банктai хамтран ажиллах, хөрөнгө оруулах, компанийн хөрөнгөөр барьцаалан баталгаа гаргах
- 6.2.7.18 Хувьцаа эзэмшигчдийн хурлаас эрх олгосон бусад асуудал.
- 6.2.8 ТУЗ-ийн ээлжит хурлыг улиралд нэг удаа хуралдуулна. Шаардлагатай гэж үзвэл нэмэлт хуралдааныг хэдийд ч хийж болно. ТУЗ-ийн хурлын шийдвэр нь тогтоол байна. Тогтоолд ТУЗ-ийн дарга гарын үсэг зурж баталгаажуулна. ТУЗ-ийн хурлын тэмдэглэлийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга хөтлөх бөгөөд түүнд хуралд оролцсон бүх гишүүд өөрийн хэлсэн үг, гаргасан саналын үнэн зөвийг хянан гарын үсгээ зурна.
- 6.2.9 ТУЗ-ийн хурлыг ТУЗ-ийн дарга, түүний гишүүд, компанийн гүйцэтгэх удирдлагын болон энэ дүрэмд заасан бусад этгээдийн санаачлага, шаардлагаар хуралдуулж болно.
- 6.2.10 ТУЗ-ийн хурлын зохион байгуулалтыг нарийн бичгийн дарга хариуцана. Мөн хурлын тухай зар, материалыг хурал хуралдахаас өмнө ТУЗ-ийн ажиллах журамд заасны дагуу гишүүдэд хүргэнэ.
- 6.2.11 ТУЗ-ийн хурлыг ТУЗ-ийн дарга удирдана. ТУЗ-ийн дарга хуралд оролцох боломжгүй тохиолдолд төлөөлөгч буюу ТУЗ-ийн шийдвэрээр аль нэг гишүүн хурлыг удирдана.
- 6.2.12 ТУЗ-ийн гишүүдийн дийлэнх олонх оролцсоноор хурал хүчин төгөлдөр болно.
- 6.2.13 Тухайн шийдвэрлэж байгаа асуудлаар ТУЗ-ийн зарим гишүүд Компанийн тухай хуульд заасны дагуу санал өгөх эрхгүй байвал шийдвэрийг саналын эрхтэй гишүүдийн дийлэнх олонхийн саналаар шийдвэрлэнэ. Гишүүн эсрэг саналтай байвал түүнийгээ тэмдэглэлд тэмдэглүүлэх эрхтэй.
- 6.2.14 ТУЗ-ийн гишүүд удаан хугацаагаар үүргээ хэрэгжүүлж чадахгүй болсон, эсхүл нас барсан тохиолдолд гишүүнийг нөхөн сонгох хүртэл ТУЗ-өөс өөр этгээдийг түүний оронд түр томилж болно.
- 6.2.15 ТУЗ-ийн гишүүдийн тоо нь нийт гишүүдийн тогтоосон тооноос 2 дахин бага болсон тохиолдолд компани нь 3 сарын дотор ТУЗ-ийн гишүүдийг сонгохоор хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг хуралдуулна.
- 6.2.16 ТУЗ-ийн гишүүдэд зохих хэмжээний урамшуулал олгох бөгөөд түүнийг хурлаас тогтооно.
- 6.2.17 ТУЗ-ийн даргыг ТУЗ-ийн анхны хурлаас гишүүдийн дотроос нийт гишүүдийн олонхийн саналаар сонгоно. ТУЗ-ийн даргын бүрэн эрхийн хугацаа 3 жил байна.
- 6.2.18 ТУЗ-ийн дарга нь ТУЗ-ийн үйл ажиллагааг зохион байгуулж, түүний хурлыг хуралдуулах, хурал даргалах, хурлын тэмдэглэлийг хөтлүүлэх, хяналт тавих үүргийг гүйцэтгэнэ.
- 6.2.19 ТУЗ-ийн даргыг түр эзгүйд түүний үүргийг даргын эсхүл ТУЗ-ийн томилсон гишүүн гүйцэтгэнэ.
- 6.2.20 ТУЗ нь шаардлагатай гэж үзвэл байнгын болон түр хороог өөрийн дэргэдээ байгуулж болно.
- 6.2.21 ТУЗ нь аудитын, цалин урамшууллын, нэр дэвшүүлэх хороодтой байх бөгөөд хороодын гишүүдийн гуравны хоёр нь хараат бус гишүүдээс бүрдэнэ. Дээрх хороод нь тодорхой чиг үүрэгтэй байх бөгөөд тухайн асуудлаар дүгнэлт гаргаж ТУЗ-д танилцуулах, компанийн тухай хуульд заасан зарим асуудлаар шийдвэр гаргах бүрэн эрхтэй.
- 6.2.22 Аудитын хорооны дарга нь ТУЗ-ийн хараат бус гишүүн байх бөгөөд уг хороо нь дараах чиглэлээр дүгнэлт гаргаж, ТУЗ-д танилцуулна. Үүнд:
- 6.2.22.1 компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийг олон улсын стандартад нийцүүлэх, дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаа, санхүүгийн тайлан, санхүү эдийн засгийн бусад мэдээллийн үнэн бодит байдалд хяналт тавих;
- 6.2.22.2 дотоод хяналтын албаны удирдлага, ажилтнуудыг томилох, цалин урамшууллыг тогтоох санал боловсруулах

- 6.2.22.3 аудитын байгууллагыг сонгох, тэдний ажлын хөлсний хэмжээг тогтоох талаар санал боловсруулах;
- 6.2.22.4 их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэлд хяналт тавих, дүгнэлт гаргах
- 6.2.23 Нэр дэвшүүлэх хороо нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд:
 - 6.2.23.1 ТУЗ-ийн гишүүн, Гүйцэтгэх захиралд нэр дэвшигчид тавих шаардлагыг тодорхойлж, ур чадвар, мэдлэг, боловсрол, ажлын туршлага зэргийг үнэлэх шалгуурыг тогтоох;
 - 6.2.23.2 ТУЗ-ийн гишүүн, Гүйцэтгэх захиралд нэр дэвшигчдийн ур чадвар, мэдлэг боловсрол, ажлын туршлага, харин хараат бус гишүүдийн хувьд шаардлагыг хангаж байгаа эсэхэд үнэлэлт, дүгнэлт өгөх;
 - 6.2.23.3 ТУЗ-ийн гишүүн, Гүйцэтгэх захиралд нэр дэвшигчдийг бүртгэн сонгон шалгаруулалт хийж, хувьцаа эзэмшигчдийн хуралд шууд нэр дэвшүүлэх;
 - 6.2.23.4 ТУЗ-ийн гишүүн, Гүйцэтгэх захирлын ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгөх;
 - 6.2.23.5 Гүйцэтгэх захиралтай байгуулах гэрээний нөхцөлийг боловсруулах;
 - 6.2.23.6 ТУЗ-ийн гишүүдээс бусад компанийн эрх бүхий албан тушаалтны ажлын гүйцэтгэлд Гүйцэтгэх захирлаас өгсөн үнэлгээнд дүгнэлт гаргах;
 - 6.2.23.7 Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулаагүйгээс бүрэн эрх нь дуусгавар болсноос ТУЗ-ийн гишүүн байсан хүнийг хуульд заасан хугацаанд нь ТУЗ-ийн гишүүнд нэрийг дэвшүүлэхээс татгалзах.
- 6.2.24 Цалин урамшуулалын хороо нь дараах чиглэлээр дүгнэлт гаргаж, ТУЗ-д танилцуулна. Үүнд:
 - 6.2.24.1 ТУЗ-ийн гишүүд, Гүйцэтгэх захирал болон бусад эрх бүхий албан тушаалтны цалин, урамшууллын талаар баримтлах бодлогыг батлах, түүний хэрэгжилтэд хяналт тавих;
 - 6.2.24.2 ТУЗ-ийн гишүүд, Гүйцэтгэх захирал болон бусад эрх бүхий албан тушаалтанд олгох цалин урамшууллын дээд хязгаарыг тогтоох, тогтоосон хэмжээнд багтаан цалин, урамшуулал олгох санал боловсруулах;
 - 6.2.24.3 Компанид мөрдөж байгаа ажлын үр дүнтэй холбогдсон компанийн урамшууллын системийн зорилгыг тодорхойлж, үр дүнг үнэлэх
- 6.2.25 Нэр дэвшүүлэх хороо нь ТУЗ-ийн хараат бус гишүүнд дараах шалгуурыг хангасан хүнийг нэр дэвшүүлнэ. Үүнд:
 - 6.2.25.1 Өөрөө эсхүл нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран компанийн энгийн хувьцааны таваас дээш хувийг эзэмшдэггүй
 - 6.2.25.2 Өөрөө эсхүл нэгдсэл сонирхолтой этгээд нь компанийн болон компани оролцогч нь болж байгаа компанийн нэгдлийн бусад оролцогчид эрх бүхий албан тушаал эрхэлдэггүй
 - 6.2.25.3 Төрийн үйлчилгээнээс бусад төрийн алба хашдаггүй
 - 6.2.25.4 Компанитай бизнесийн аливаа холбоогүй
- 6.2.26 **Хараат бус гишүүн нь бусад гишүүдийн адил эрх, үүрэгтэй байхаас гадна дараах нэмэлт үүрэгтэй. Үүнд:**
 - 6.2.26.1 ТУЗ ба Гүйцэтгэх захирлын үйл ажиллагаа, гаргасан бодлого, шийдвэр нь компанийн эрх ашигт сөргөөр нөлөөлсөн эсэх, үйл ажиллагаа нь хууль тогтоомж, дүрэм, журамд нийцсэн эсэхэд хяналт тавих,
 - 6.2.26.2 зөрчил илэрвэл уг асуудлыг ТУЗ-д тавьж шийдвэрлүүлэх, улмаар хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулах шаардлагыг хүргүүлэх
 - 6.2.26.3 компанийн үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах талаар Гүйцэтгэх захиралд үүрэг өгч, хэрэгжилтийг хянах, холбогдох этгээдээс шаардах;
 - 6.2.26.4 хувьцаа эзэмшигчдийн хуралд биечлэн оролцож, ТУЗ-ийн шийдвэрийн талаар зарчмын зөрүүтэй байр суурьтай байсан бол энэ тухайгаа мэдээлж, хувьцаа эзэмшигчдийн асуултад хариулах, тодруулга хийх.

6.2.27 ТУЗ нь даргын санал болгосноор ТУЗ-өөс томилсон нарийн бичгийн даргатай байх ба нарийн бичгийн дарга нь компанийн тухай хуулийн 82.2-т заасан үүргийг хүлээнэ.

6.2.28 ТУЗ-ийн нарийн бичгийн даргын бүрэн эрхийн хугацаа 3 жил байна.

6.3 Гүйцэтгэх удирдлага

6.3.1 Компанийн Гүйцэтгэх удирдлагыг хувь хүн /цаашид "Гүйцэтгэх захирал" гэх/-аар хэрэгжүүлнэ. Компанийн гүйцэтгэх захирал нь энэ дүрэм болон Контракт гэрээнд заасан эрх хэмжээний хүрээнд компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдана.

6.3.2 ТУЗ компанийн Гүйцэтгэх захирлыг түүнтэй байгуулсан гэрээний үндсэн дээр томилно.

6.3.3 Гүйцэтгэх захирал нь ТУЗ-ийн гишүүн байх, өөр компани, аж ахуй нэгжийн гүйцэтгэх удирдлагад ажиллаж болно. Харин ТУЗ-ийн дарга байж болохгүй. Гүйцэтгэх захирал нь компанийн нэрийн өмнөөс гэрээ хэлэлцээр хийх болон бусад байдлаар компанийг төлөөлөхдөө тусгайлсан итгэмжлэл авахгүй бөгөөд дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд:

6.3.3.1 Компанийн хэтийн төлөв, бодлого, үйл ажиллагааны чиглэлийн талаар санал боловсруулах, ТУЗ-ийн хуралд оруулж батлуулах хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

6.3.3.2 Хараат (охин) компани, салбар, төлөөлөгчийн газрын захирлуудыг томилох саналыг ТУЗ-д оруулж батлуулах, тэдэнтэй компанийг төлөөлөн контракт гэрээ байгуулах;

6.3.3.3 Компанийн хөрөнгийг ТУЗ-өөс тогтоосон эрх хэмжээний хүрээнд захиран зарцуулах;

6.3.3.4 Компанийн дотоод журам, үйл ажиллагааны дүрэм, журам, зааврыг баталж, мөрдүүлэх;

6.3.3.5 Өөрийн эрх хэмжээний хүрээнд тушаал гаргах;

6.3.3.6 ТУЗ-өөс олгосон эрх мэдлийн хүрээнд компанийг төлөөлж гадаад, дотоодын байгууллага, хувь хүмүүстэй шууд харилцаж, тэдэнтэй гэрээ, хэлэлцээр байгуулах;

6.3.3.7 Компанийг төлөөлөх итгэмжлэл олгох;

6.3.3.8 Компанийн бүтээгдэхүүний дотоод болон гадаад орнуудад мөрдөх үнэ, тарифыг батлан мөрдүүлэх;

6.3.3.9 Монгол Улсын хууль тогтоомж, шийдвэр болон ТУЗ-ийн тогтоолын биелэлтийг зохион байгуулна. ТУЗ-өөс баталсан төсвийн хүрээнд компанийн бүтэц, орон тоог бие даан баталж мөрдүүлэх;

6.3.3.10 Компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн үнэн зөвийг хариуцах;

6.3.3.11 Хувьцаа эзэмшигчдийг ТУЗ-ийн хурлын шийдвэр, компанийн санхүүгийн тайлантай танилцах боломжоор хангах;

6.3.3.12 ТУЗ-ийн хуралд компанийн хагас, бүтэн жилийн үйл ажиллагааны талаар тайлагнах.

6.3.4 Гүйцэтгэх захирал нь ажлаа ТУЗ-д тайлагнах ба ТУЗ нь гүйцэтгэх захирлын бүрэн эрхийг зогсоох шийдвэрийг хэдийд ч гаргах эрхтэй.

6.3.5 Гүйцэтгэх захиралтай байгуулсан гэрээг цуцалсан буюу цуцлах тухай санал тавьсан тохиолдолд Гүйцэтгэх захирлыг шинээр сонгох хүртэл ТУЗ-өөс томилсон этгээд Гүйцэтгэх захирлын үүргийг түр гүйцэтгэнэ.

6.3.6 Гүйцэтгэх захирал нь ТУЗ-ийн хурал хуралдуулах тухай саналыг ТУЗ-ийн дарга, болон гишүүнд гаргаж болно.

Долоо. Компанийн эрх бүхий албан тушаалтан, түүний хүлээх хариуцлага

7.1. ТУЗ-ийн Дарга, гишүүд, нарийн бичгийн дарга, компанийн Гүйцэтгэх захирал, дэд захирлууд, газрын захирлууд зэрэг албан тушаалтныг компанийн эрх бүхий албан тушаалтанд тооцно.

7.2. Компанийн эрх бүхий албан тушаалтан нь дараах үүрэгтэй:

- 7.2.1 Компанийн тухай хууль, энэхүү дүрэм, ТУЗ-өөс баталсан дотоод журамд заасан бүрэн эрхийн хүрээнд ажиллаж, компанийн эрх ашгийг дээдлэх зарчмыг баримтална;
- 7.2.2 ТУЗ-ийн зөвшөөрснөөс бусад тохиолдолд компанийн нууцад хамрагдах мэдээ, тайлан, гэрээ, эрхийн холбогдолтой материалыг гурав дахь этгээдэд дамжуулах болон хувийн ашиг сонирхлын төлөө ашиглахгүй;
- 7.2.3 шийдвэр гаргах, шийдвэр гаргах ажиллагаанд оролцохдоо холбогдох бүх мэдээллийг бүрэн судалж, шийдвэрийн үндэслэлд бүрэн итгэлтэй байх;
- 7.2.4 шийдвэр гаргахдаа сонирхлын зөрчлөөс зайлсхийж, сонирхлын зөрчил үүссэн бол энэ тухайгаа заавал мэдэгдэж, шийдвэр гаргахад оролцохгүй байх;
- 7.2.5 өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэхдээ гуравдагч этгээдээс бэлэг урамшуулал авахгүй, аливаа хэлбэрээр нөлөөнд автахгүй байх;
- 7.2.6 эрх бүхий албан тушаалд томилогдсоноос хойш 10 хоногийн дотор өөрийн нэгдмэл сонирхолтой этгээдийн нэрсийн жагсаалтыг ТУЗ-ийн нарийн бичгийн даргад өгөх бөгөөд уг жагсаалтад гарсан өөрчлөлтийн талаар өөрчлөлт гарснаас хойш 10 хоногийн дотор мэдэгдэж байна.
- 7.3. Албан тушаалаас өөрчлөгдсөнөөс хойш 3 жилийн хугацаанд энэ дүрмийн 7.2.2-т заасан үүргийг хүлээнэ.
- 7.4. Албан тушаалтан энэ дүрмийн 7.2 болон 7.3-т заасан үүргээ хэрэгжүүлээгүй, удаа дараа зөрчсөн, мөн тэдгээрийн дор дурдсан үйлдэл, эс үйлдлийн улмаас компани хувьцаа эзэмшигчид болон зээлдүүлэгчид бусад оролцогч талуудад хохирол учруулсан бол учруулсан хохирлыг өөрийн хөрөнгөөр хариуцан барагдуулна. Үүнд:
- 7.4.1 компанийн нэрийг хувийн сонирхлоор ашигласан;
- 7.4.2 хувьцаа эзэмшигч, зээлдүүлэгч, бусад оролцогчдод хуурамч мэдээлэл өгсөн;
- 7.4.3 эрх бүхий этгээдэд мэдээлэл өгөх үүргээ биелүүлээгүй;
- 7.4.4 Компанийн тухай хуулийн 97 дугаар зүйлд заасан компанийн баримт бичгийг зохих журмын дагуу хадгалаагүй;
- 7.4.5 Компанийн тухай хуулийн 98 дугаар зүйлд заасан мэдээллийг хувьцаа эзэмшигчид гаргаж өгөөгүй, эсхүл хугацаа хоцруулан гаргаж өгснөөс хувьцаа эзэмшигчид учирсан хохирлыг нөхөн төлөхөөс гадна энэ шалтгаанаар компанид торгуулийн арга хэмжээ оногдуулсан бол энэхүү торгуулийг тухайн эрх бүхий албан тушаалтнаар төлүүлнэ.
- 7.5 Эрх бүхий албан тушаалтан нь Компанийн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.4, 84.5-д заасан үүргээ биелүүлээгүй, удаа дараа зөрчсөнөөс компанид хохирол учруулсан бол хохирлыг өөрийн хөрөнгөөр нөхөн төлнө.
- 7.6 Компанийн эрх бүхий албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх, хариуцлагын хэмжээг тогтоох асуудлыг ТУЗ-ийн үйл ажиллагааны журам, эрх бүхий албан тушаалтантай байгуулсан хөдөлмөрийн гэрээ, компанийн дотоод журмын дагуу шийдвэрлэх ба боломжгүй бол шүүхээр шийдвэрлүүлнэ.

**Найм. Компанийн санхүүгийн үйл ажиллагаа, бүртгэл тайлан,
ногдол ашгийн хуваарилалт**

- 8.1 Компани нь холбогдох хуулиар тогтоосон журмын дагуу нягтлан бодох бүртгэл хөтлөн санхүүгийн тайлан гаргаж, хувьцаа эзэмшигч болон эрх бүхий бусад этгээдэд танилцуулна. Санхүүгийн зохицуулах хороо болон хөрөнгийн биржээс тогтоосон нэмэлт мэдээллийг санхүүгийн тайлангийн хамт дээрх газруудад зохих хугацаанд нь хүргүүлэн нийтэд мэдээлэх үүрэгтэй.
- 8.2 Компанийн санхүүгийн жилийн эхлэх хугацаа жил бүрийн 1-р сарын 1, дуусах хугацаа 12-р сарын 31 байна.
- 8.3 Компани нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах бөгөөд түүний үнэн зөвийг Санхүү бүртгэлийн хэлтсийн захирал Гүйцэтгэх захиралтай хамтран хариуцна.
- 8.4 Компани дор дурдсан бүртгэлийг заавал хөтөлнө. Үүнд:
- 8.4.1 Үнэт цаас эзэмшигчдийн бүртгэлийг компани хариуцна.

- 8.4.2 Хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийг энэ талаар тусгай зөвшөөрөл бүхий этгээдтэй гэрээ байгуулан хөтлүүлнэ.
- 8.5. Компани нягтлан бодох бүртгэлийн хуульд заасан журмын дагуу тухайн жилийн санхүүгийн тайлан гаргаж нийтлүүлнэ.
- 8.6. Санхүүгийн тайланд дараах үндсэн бүрдэл хэсгүүд заавал орсон байна. Үүнд:
- 8.6.1 Баланс:
 - 8.6.2 Орлого үр дүнгийн тайлан:
 - 8.6.3 Мөнгөн гүйлгээний тайлан:
 - 8.6.4 Хуримтлагдсан ашгийн тайлан:
 - 8.6.5 Тухайн тайлангийн хугацаанд хийгдсэн хэлцэл болон сонирхлын зөрчил бүхий хэлцлийн жагсаалт, нэр төрөл, үнийн дүн
 - 8.6.6 Удирдлагад олгосон цалин шагнал, урамшуулал
- 8.7 Санхүүгийн тайлан гаргахад хэрэглэсэн хөрөнгийн үнэлгээ, элэгдэл тооцсон аргууд, орлогын зохицуулалт, хараат болон охин компаниудад оруулсан санхүүгийн хөрөнгө оролцооны хувь хэмжээ, ногдол ашгийн бодлого, хуримталсан ашиг, үнэ ханшны хэлбэлзлийг тайланд хэрхэн тусгасан тухай болон хууль тогтоомжид заасан шаардлагатай бусад тайлбар, тодруулгыг заавал хийсэн байна.
- 8.8 Нягтлан бодох бүртгэлийн хуулийн дагуу Сангийн сайдын баталсан санхүүгийн тайлангийн дэлгэрэнгүй үзүүлэлтүүд, маягт, аргачлалыг мөрдөнө.
- 8.9 Ногдол ашиг хуваарилах эсэх шийдвэрийг ТУЗ санхүүгийн жил дууссанаас хойш 50 хоногийн дотор гаргах ба ногдол ашиг хуваарилахгүй гэж шийдвэрлэсэн тохиолдолд энэ тухай үндэслэлээ хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд тайлагнана.
- 8.10 ТУЗ нь ногдол ашиг хуваарилахдаа хувьцаа бүрт ногдох ашгийн хэмжээ, ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах, бүртгэлийн өдөр болон ногдол ашиг төлөх өдрийг тогтоож энэ талаар хувьцаа эзэмшигчдэд мэдэгдэнэ.
- 8.11 Ногдол ашгийг бэлэн мөнгө болон эд хөрөнгийн, түүнчлэн компанийн болон бусад этгээдийн үнэт цаасны хэлбэрээр төлж болно. Энэ тухай шийдвэрийг ТУЗ гаргана.
- 8.12 Компанийн жилийн санхүүгийн тайлан гарсны дараа дор дурдсан нөхцөлд цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилна. Үүнд:
- 8.12.1 Ногдол ашиг төлсний дараа компани төлбөрийн чадвартай байх:
 - 8.12.2 Ногдол ашиг төлсний дараа компанийн өөрийн хөрөнгө нь давуу эрхийн хувьцааны төлөгдөөгүй ногдол ашиг, татан буулгалтын үнэ хуульд заасан өөрийн хөрөнгийн доод хэмжээний нийлбэрээс илүү байх:
 - 8.12.3 Компани эргүүлэн авах үүрэгтэй үнэт цаасаа бүрэн авсан байх:
- 8.13 Ногдол ашиг хуваарилсны дараа компанийн өөрийн хөрөнгө нь хуваарилахын өмнөх хэмжээнээс 25-аас илүү хувиар багассан тохиолдолд ногдол ашгийг шилжүүлснээс хойш ажлын 15 хоногийн дотор эзэлдүүлэгчдэдээ өөрийн хөрөнгийн үлдэгдлийн хэмжээг бичгээр мэдэгдэнэ. Энэ үүргийг гүйцэтгэх захирал хэрэгжүүлнэ.
- 8.14 Ногдол ашиг хуваарилаагүй бол ТУЗ шалтгааныг хувьцаа эзэмшигчдийн хуралд тайлагнана. Ногдол ашиг хуваарилсны дараа үлдэх ашгаас нийгэм, соёлын арга хэмжээ, үйлдвэр хөгжүүлэх сан байгуулж болно. Санг байгуулах асуудлыг ТУЗ шийдвэрлэнэ. Уг санг байгуулах, түүний хөрөнгийг зарцуулах журмын төслийг Гүйцэтгэх захирал боловсруулж ТУЗ-ийн хурлаар батлуулж мөрдөнө.
- 8.15 Давуу эрхийн хувьцаанд хуваарилах ногдол ашгийг тусгайлан байгуулсан сангаас олгож болно.
- 8.16 Компани нь ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн бол уг шийдвэрт заасан хугацаанд ногдол ашгийг хуваарилна.
- 8.17 Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.10-т заасан хугацаанд ногдол ашгаа аваагүй нь тухайн хувьцаа эзэмшигчийн ногдол ашиг авах эрхийг үгүйсгэх, эсхүл тухайн компани ногдол ашиг олгохгүй байх үндэслэл болохгүй.
- 8.18 Ногдол ашгаа аваагүй хувьцаа эзэмшигчийн ногдол ашгийг түүнд төлөх өр болгон нягтлан бодох бүртгэлд хувьцаа эзэмшигчийн нэрээр тусгайлан бүртгэж хадгалах бөгөөд компани хувьцаа эзэмшигчийн анхны шаардлагаар ногдол ашгийг олгох үүрэгтэй.

- 8.19 Ногдол ашиг хуваарилалтын тайланг ногдол ашиг хуваарилж дууссан өдрөөс хойш ажлын 15 өдрийн дотор гаргаж, Санхүүгийн зохицуулах хорооноос тогтоосон хугацаанд уг хороо болон үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад хүргүүлнэ.
- 8.20 ТУЗ нь ногдол ашиг хуваарилалтын тайланг хувьцаа эзэмшигчдийн дараагийн хуралд заавал тайлагнана.
- 8.21 Хувьцаа эзэмшигч ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн жагсаалт гаргах өдрөөс ногдол ашиг төлөх өдөр хүртэл хугацаанд өөрийн эзэмшлийн хувьцааг бусдад шилжүүлсэн бол ногдол ашиг авах эрх нь тэдгээрийн хооронд байгуулсан гэрээнд өөрөөр заагаагүй бол уг хувьцааны хуучин эзэмшигчид үлдэнэ.

Ес. Компанийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд тавих хяналт

- 9.1 Аудитын тухай Монгол улсын хуульд заасны дагуу компани нь санхүүгийн тайлангаа шалгуулж баталгаажуулах, санхүү эдийн засгийн үйл ажиллагаанд бүрэн болон хэсэгчилсэн шалгалт хийлгэх зорилгоор гэрээний үндсэн дээр аудиторыг ажиллуулна.
- 9.2 Санхүү эдийн засгийн үйл ажиллагаанд хийх аудиторын шалгалт нь ээлжит ба ээлжит бус байна.
- 9.3 Компанийн жилийн санхүүгийн тайланд дүгнэлт өгөхийн тулд ээлжит шалгалт хийнэ.
- 9.4 Ээлжит бус шалгалтыг ТУЗ-ийн шийдвэр компанийн энгийн хувьцааны 10-аас дээш хувийг эзэмшиж буй хувьцаа эзэмшигч, Гүйцэтгэх захирлын саналаар хэдийд ч хийж болно.
- 9.5 Компанийн ТУЗ аудиторыг сонгож түүнтэй байгуулах гэрээг батална. Гэрээнд компанийн болон аудиторын эрх үүрэг, хариуцлага, аудиторт төлөх хөлсний хэмжээг заана.
- 9.6 Аудиторын ээлжит шалгалтын хөлсийг компани хариуцан төлөх бөгөөд ээлжит бус шалгалтыг түүнийг захиалж гэрээг нь байгуулж хийлгэсэн хувьцаа эзэмшигч хариуцаж төлнө. Шалгалтын явцад компанийн эрх бүхий албан тушаалтан компани болон хувьцаа эзэмшигчдэд хохирол учруулсан нь тогтоогдвол шалгалтын хөлсийг буруутай этгээд хариуцан төлнө.
- 9.7 Компанийн эрх бүхий албан тушаалтан аудиторын шаардлагаар компанийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагааны талаарх баримт бичгийг танилцуулах үүрэгтэй.
- 9.8 Аудитор нь хувьцаа эзэмшигчдийн хуралд зөвхөн тайлбар өгөх үүрэгтэй оролцож болно.
- 9.9 Дараах этгээдийг компанийн аудиторoor сонгон ажиллуулахыг хориглоно. Үүнд:
- 9.9.1 Компанийн нэгдмэл сонирхолтой этгээд, компанийн эрх бүхий албан тушаалтан, тэдгээртэй нэгдмэл зорилготой этгээд компанийн буюу нэгдмэл сонирхолтой компанийн хөлсний ажилчин;
- 9.9.2 Компанийн болон түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдийн гаргасан үнэт цаас эсвэл Компанийн болон түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдэд холбогдох бусад эд хөрөнгө буюу эд хөрөнгийн эрх эзэмшигч;
- 9.9.3 Компанитай аудитаас бусад асуудлаар аливаа хэлцэл хийсэн этгээд.
- 9.10 Аудиторт олгох хөлсний хэмжээг түүний гаргасан дүгнэлтийн шинж чанараас хамааруулан тогтоохыг хориглоно.
- 9.11 Аудитор нь дүгнэлтээ зөвхөн бичгээр гаргана.

Арав. Компанийг татан буулгах

- 10.1 Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын болон шүүхийн шийдвэрээр Иргэний хууль, Компанийн тухай хууль болон бусад хуульд заасан үндэслэл, журмаар татан буулгана.
- 10.2 Монгол Улсын шүүх компанийг дор дурдсан үндэслэлээр татан буулгана. Үүнд:
- 10.2.1 Дампуурсан;
- 10.2.2 Нэг ч хувьцаа эзэмшигч үлдээгүй;
- 10.2.3 Хуульд заасан бусад үндэслэл;
- 10.3 Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрээр татан буугдаж байгаа компанийн ТУЗ нь компанийг татан буулгах комисс томилох, татан буулгах хугацаа, журам, зээлдүүлэгчдийн нэхэмжлэлийг барагдуулсны дараагаар компанид үлдэж байгаа эд

- хөрөнгийг хуваарилах төслийг бэлдэж хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулан, хуралд оролцогчдын саналын дийлэнх олонхоор шийдвэрлэнэ.
- 10.4 Татан буулгах комисс томилсноор компанийн Гүйцэтгэх захирлын бүрэн эрх дуусгавар болж, татан буулгах комисст шилжих бөгөөд уг комисс нь компанийн нэрийн өмнөөс шүүх хуралд төлөөлөн оролцоно. Татан буулгах комисс дараах үүрэг гүйцэтгэнэ. Үүнд:
- 10.4.1 Компанийг татан буулгах шийдвэрийг нийтэд мэдээлэх;
 - 10.4.2 Дуусгалтын баланс, тайлан гаргаж хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэх;
 - 10.4.3 Өр төлбөрийг хуульд заасан дараалал журмын дагуу батлах;
 - 10.4.4 Үлдсэн эд хөрөнгийг хуульд заасан журмын дагуу хувьцаа эзэмшигчдэд хуваарилах;
 - 10.4.5 Татан буулгах ажиллагаа дууссаныг Улсын бүртгэлийн албанд мэдэгдэж, бүртгэлээс хасуулах.
- 10.5 Татан буулгах комисс үүргээ биелүүлэх үедээ өөрийн буруутай үйл ажиллагааны улмаас компанид эсвэл зээлдүүлэгчид ямар нэг хохирол учруулсан бол уг хохирлыг хуульд заасны дагуу хариуцна.
- 10.6 Татан буулгах комисс нь компанийг татан буулгах болон нэхэмжлэл гаргах хугацаа журмыг нийтэд болон зээлдүүлэгчид мэдээлнэ. Нэхэмжлэл гаргах хугацаа нь татан буулгах хугацааг нийтэд мэдээлснээс хойш хоёр сараас доошгүй, зургаан сараас дээшгүй байна.
- 10.7 Татан буулгах шийдвэр гарах үед компани ямар нэг өргүй байвал компанийг татан буулгах тухай нийтэд мэдээлэхгүй байж болно.
- 10.8 Нэхэмжлэл гаргах хугацаа дууссан өдрөөр тасалбар болгон компанийн эд хөрөнгө, эд хөрөнгийн эрх, зээлдүүлэгчдийн гаргасан нэхэмжлэлийн шаардлагын дүнг тусгасан татан буулгах түр балансыг гаргах бөгөөд уг балансыг хувьцаа эзэмшигчдийн хурал батална.
- 10.9 Татан буулгах комисс нэхэмжлэлийг хэрхэн барагдуулах тухайгаа нэхэмжлэгчдэд бичгээр мэдэгдэнэ.
- 10.10 Компанийн мөнгөн хөрөнгө нь нэхэмжлэлийг барагдуулахад хангалтгүй бол татан буулгах комисс компанийн эд хөрөнгийг худалдаж болно. Зээлдүүлэгчдийн өр төлбөрийг барагдуулсны дараа үндсэн эд хөрөнгө эсвэл тэдгээрийг худалдаж борлуулсны орлогыг хувьцаа эзэмшигчдэд тэдгээрийн эзэмшиж буй хувьцааны тоотой хувь тэнцүүлж хуваарилна.
- 10.11 Компанийн бүх эд хөрөнгийг хуваарилсны дараа татан буулгах комисс компанийг татан буулгах замаар үйл ажиллагаа дуусгавар болсныг бүртгэх байгууллагад мэдэгдэж, татан буулгах балансын нэг хувийг хүргүүлнэ.
- 10.12 Компанийг бие даасан өөр компанитай нэгтгэж шинээр компани байгуулах, эсвэл өөр компанийг өөртөө нийлүүлэх буюу өөрөө өөр компанид нийлэх, түүнчлэн компанийг бие даасан хэд хэдэн компани болгон хуваах буюу компаниас өөр компани шинээр тусгаарлах аргаар өөрчлөн байгуулж болно.
- 10.13 Компани нь өөртөө өөр компани нийлүүлсэн, өөрөөсөө шинээр компани тусгаарлан гаргасан тохиолдолд тус компани нь хуулийн этгээдийн бүрэн эрхээ хадгалж үлдэнэ.

Арван нэг. Ахмадын сангийн тухай

- 11.1 Компани нь ажиллаж байсан ахмад настанд Ахмад настны тухай хуулийн 14.6-д заасан арга хэмжээнд дэмжлэг үзүүлэх зорилгоор "Ахмадын сан" байгуулан ажиллуулна.
- 11.2 Ахмадын сангийн мөнгөн хөрөнгийн хэмжээг гүйцэтгэх удирдлага нь 2 жилд нэг удаа Үйлдвэрчний эвлэл болон түүний дэргэдэх Ахмадын зөвлөлтэй хэлэлцэн тогтооно.

Арван хоёр. Дүрмийн нэмэлт, өөрчлөлт

- 12.1. Компанийн ТУЗ нь шаардлагатай тохиолдолд энэхүү дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах болон шинэчилсэн найруулгыг хийх бол энэ талаар санал боловсруулан хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулж батлуулна.
- 12.2 Энэхүү дүрэм нь улсын бүртгэлд бүртгэгдсэн өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.



**“ГОВЬ” ХУВЬЦААТ КОМПАНИ
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ
ХУРЛЫН ТОГТООЛ**

2025 оны 04 сарын 25 өдөр

Дугаар 03

Улаанбаатар хот

Г Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2025 оны
цалингийн төсвийг батлах тухай Г

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13, Компанийн дүрмийн 6 дугаар зүйлийн 6.1.9.12 дахь заалтуудыг тус тус удирдлага болгон 2025 оны 04-р сарын 25-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Говь ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны цалингийн төсвийг дараах байдлаар баталсугай.

/төгрөг/

Агуулга	2024 он	2025 он		
	Төсөв	Төсөв	Өөрчлөлт	
			төгрөг	хувь
Тогтмол цалин	211,200,000	237,200,000	26,000,000	12%
Оролцооны цалин	50,700,000	59,150,000	8,450,000	17%
НДШ	30,118,500	32,598,500	2,480,000	8%
Нийт цалин	292,018,500	328,948,500	36,930,000	13%

2. Батлагдсан төсвийн гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Цалин, урамшууллын хороонд үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Д.ГЭРЭЛМАА



**“ГОВЬ” ХУВЬЦААТ КОМПАНИ
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ
ХУРЛЫН ТОГТООЛ**

2025 оны 04 сарын 25 өдөр

Дугаар 04

Улаанбаатар хот

Г Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийг сонгон Г
томилох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7, 77 дугаар зүйлийн 77.1, 77.4, Компанийн дүрмийн 6 дугаар зүйлийн 6.1.9.8, 6.2.3 дахь заалтуудыг тус тус удирдлага болгон 2025 оны 04-р сарын 25-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Говь ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн бүрэн эрхийн хугацааг дуусгавар болгосугай.
2. Говь ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүдээр:

Дамбын ГЭРЭЛМАА
Алтангэрэлийн ЖАРГАЛМАА
Дамбийжавын ХҮРЭЛБААТАР нарыг;

Говь ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн гишүүдээр:

Баатарсайханы АМАРСАЙХАН
Цагаачийн БААТАРСАЙХАН
Цогтгэрэлийн ОРГИЛБОЛД
Дашдаваагийн ХУЛАН
Батжаргалын ОРГИЛ

Баатарсүрэнгийн ЦЭЭНЯМ нарыг тус тус 3 жилийн хугацаагаар сонгон томилсугай.

ХУРЛЫН ДАРГА



Д.ГЭРЭЛМАА